



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангал сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/029/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт

Утас: 70342716

Цахим хаяг: battsogtd@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном

Утас: 70342495

Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.10 № 26

танай _____ ны № _____ т

Г ХАНГАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН Г
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Л.САЙНГЭРЭЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хангал сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүйгээс 3 албан хаагчид 10,125.0 мянган төгрөгийн цалин илүү олгосон,
- Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгохдоо тогтоосон дээд хэмжээг баримтлаагүй 3,098.0 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон,
- Хууль, журамд тусгаагүй 5,512.7 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн "16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан

6325050034

тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.", 2.2. Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хангал сумын Засаг даргын тамгын газар нь 5 сарын хугацаанд түр орлон гүйцэтгэгчтэй ажилласан байна. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхэд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 39,155.9, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 623,134.6 нийт 662,290.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Хангал сумын Засаг даргын тамгын газар нь 1 хөтөлбөр 10 арга хэмжээний хүрээнд 1,401,802.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, 1,253,953.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг

буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан		төгрөгөөр/
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>202,289,688.10</u>	<u>269,765,564.39</u>
АВЛАГА	316,575.65	20,816,575.65
Ажиллагчидтай холбогдсон авлага	316,575.65	816,575.65
Бусад авлага	-	20,000,000.00
Байгууллагаас авах авлага	-	20,000,000.00
БАРАА МАТЕРИАЛ	201,973,112.45	218,887,488.74
Хангамжийн материал	197,313,112.45	212,987,488.74
Бичиг хэргийн материал	5,672,290.00	5,491,740.00
Аж ахуйн материал	26,244,519.40	24,542,769.00
Сэлбэг хэрэгсэл	7,681,500.00	5,175,500.00
Түлш, шатах тослох материал	33,730.00	5,555,547.50
Бусад хангамжийн материал	157,681,073.05	172,221,932.24
Мал амьтад	4,660,000.00	5,900,000.00
НӨӨЦИЙН БАРАА	-	30,061,500.00
Тэжээлийн нөөц	-	30,061,500.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,445,292,566.61</u>	<u>2,927,846,150.24</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,445,292,566.61	2,927,846,150.24
Биет хөрөнгө	1,601,788,918.17	2,084,892,502.32
Барилга, байгууламж, орон сууц	1,378,642,722.44	1,931,738,362.44
Хуримтлагдсан элэгдэл	(287,802,378.09)	(366,635,810.78)
Авто-тээврийн хэрэгсэл	213,321,800.00	290,415,134.00
Хуримтлагдсан элэгдэл	(82,476,014.47)	(114,713,675.80)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	294,130,989.00	338,251,549.93
Хуримтлагдсан элэгдэл	(143,099,409.38)	(192,915,200.88)
Тавилга, аж ахуйн эд хогшил	124,459,000.00	130,540,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(55,406,777.38)	(72,010,284.58)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	90,000,000.00	90,000,000.00
Бусад үндсэн хөрөнгө	136,335,763.15	138,135,763.15
Хуримтлагдсан элэгдэл	(66,316,777.10)	(87,913,335.16)
Биет бус хөрөнгө	843,503,648.44	842,953,647.92
Програм хангамж	4,756,800.00	4,756,800.00
Хуримтлагдсан элэгдэл	(2,706,799.56)	(3,256,800.08)
Бусад биет бус хөрөнгө	841,453,648.00	841,453,648.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,647,582,254.71</u>	<u>3,197,611,714.63</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>482,345.99</u>	<u>2,793,601.75</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	482,345.99	2,793,601.75
Өглөг	482,345.99	2,793,601.75
Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,951,944.75
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	841,657.00
Бусад өглөг	482,345.99	-
Хувь хүмүүст төлөх өглөг	482,345.99	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,647,099,908.72</u>	<u>3,194,818,112.88</u>

Засгийн газрын хувь оролцоо	2,647,099,908.72	3,194,818,112.88
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	245,829,377.90	245,829,377.90
Өмч: - төрийн	245,829,377.90	245,829,377.90
Хуримтлагдсан үр дүн	2,374,019,671.35	2,921,737,875.51
Өмнөх үеийн үр дүн	2,374,019,671.35	2,374,019,671.35
Тайлант үеийн үр дүн	-	547,718,204.16
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,250,859.47	27,250,859.47
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,647,582,254.71	3,197,611,714.63

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,342,593,936.86	1,974,146,740.54
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,950,000.00	698,046,139.93
Нийтлэг татварын бус орлого	6,950,000.00	698,046,139.93
Төсөв байгууллагын өөрийн орлого	6,950,000.00	698,046,139.93
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,950,000.00	793,500.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө		643,034,634.93
Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал		54,218,005.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,335,643,936.86	1,276,100,600.61
Нэмэлт санхүүжилтийн орлого	80,033,000.00	22,940,918.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,924,000.00	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,109,000.00	21,750,918.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,190,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,255,610,936.86	1,253,159,682.61
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,255,610,936.86	1,218,159,682.61
Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	-	35,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,416,116,713.08	1,426,428,536.38
УРСГАЛ ЗАРДАЛ	1,416,116,713.08	1,426,428,536.38
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,377,063,528.08	1,385,599,933.38
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	740,804,395.31	725,916,790.82
Үндсэн цалин	345,376,855.33	352,124,273.60
Нэмэгдэл	323,425,169.54	301,243,076.32
Унаа хоолны хөнгөлөлт	22,661,606.44	27,098,446.04
Урамшуулал	49,340,764.00	45,450,994.86
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,418,734.19	92,528,451.24
Тэтгэврийн даатгал	65,009,385.03	63,379,265.48
Тэтгэмжийн даатгал	7,733,124.81	7,423,866.47
ҮОМШӨ-ний даатгал	3,804,525.99	3,620,903.21

Ажилгүйдлийн даатгал	3,752,148.79	3,620,903.21
Эрүүл мэндийн даатгал	15,119,549.57	14,483,512.87
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,764,186.46	158,353,489.26
Гэрэл, цахилгаан	14,361,948.49	20,479,953.90
Түлш, халаалт	134,402,237.97	137,873,535.36
Хангамж, бараа материалын зардал	39,021,469.00	38,960,073.71
Бичиг хэрэг	3,347,600.00	5,004,250.00
Тээвэр, шатахуун	30,075,050.00	11,140,432.50
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,508,300.00	2,961,200.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,350,000.00	4,380,250.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,740,519.00	13,013,941.21
Бараа материал акталсны зардал	-	2,460,000.00
Нормативт зардал	15,500.00	289,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,500.00	289,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	25,127,500.00	23,450,905.00
Багаж, техник, хэрэгсэл	-	2,210,100.00
Урсгал засвар	25,127,500.00	21,240,805.00
Томилолт, зочны зардал	21,647,863.00	33,733,357.00
Гадаад албан томилолт	10,759,863.00	29,430,157.00
Дотоод албан томилолт	10,888,000.00	4,303,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,989,076.00	22,789,050.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,173,871.00	21,161,735.00
Даатгалын үйлчилгээ	407,100.00	562,930.00
Тээврийн хэрэгслийн татвар	298,105.00	504,385.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	450,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	266,274,804.12	289,578,816.35
Бараа үйлчилгээний бусад зардал	94,659,555.00	88,693,865.05
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,806,500.00	1,248,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	130,808,749.12	199,636,951.30
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,053,185.00	40,828,603.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	38,828,603.00
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	38,828,603.00
Бусад урсгал шилжүүлэг	39,053,185.00	2,000,000.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,457,185.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,596,000.00	2,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(73,522,776.22)	547,718,204.16
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	4,092,000.00	-
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	4,092,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,164,596.91	-
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,164,596.91	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	927,403.09	-
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(72,595,373.13)	547,718,204.16

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,343,211,436.86	1,276,894,100.61
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,567,500.00	793,500.00
Нийтлэг татварын бус орлого	7,567,500.00	793,500.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	7,567,500.00	793,500.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	617,500.00	793,500.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,950,000.00	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,335,643,936.86	1,276,100,600.61
Нэмэлт санхүүжилтийн орлого	80,033,000.00	22,940,918.00
ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,924,000.00	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,109,000.00	21,750,918.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,190,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,255,610,936.86	1,253,159,682.61
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,255,610,936.86	1,218,159,682.61
Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	-	35,000,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,305,056,446.86	1,237,738,200.61
УРСГАЛ ЗАРДАЛ	1,305,056,446.86	1,237,738,200.61
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,266,003,261.86	1,177,437,097.61
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	739,808,377.71	725,164,074.81
Үндсэн цалин	344,380,837.73	353,106,619.59
Нэмэгдэл	323,425,169.54	301,243,076.32
Унаа хоолны хөнгөлөлт	22,661,606.44	27,098,446.04
Урамшуулал	49,340,764.00	43,715,932.86
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,418,734.19	92,311,568.49
Тэтгэврийн даатгал	65,009,385.03	63,162,382.73
Тэтгэмжийн даатгал	7,733,124.81	7,423,866.47
ҮОМШӨ-ний даатгал	3,804,525.99	3,620,903.21
Ажилгүйдлийн даатгал	3,752,148.79	3,620,903.21
Эрүүл мэндийн даатгал	15,119,549.57	14,483,512.87
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,764,186.46	158,353,489.26
Гэрэл, цахилгаан	27,270,368.77	20,479,953.90
Түлш, халаалт	121,493,817.69	137,873,535.36
Хангамж, бараа материалын зардал	28,532,640.00	36,826,800.00
Бичиг хэрэг	3,714,800.00	4,758,100.00
Тээвэр, шатахуун	17,981,940.00	14,487,250.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,410,300.00	2,961,200.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,235,000.00	10,280,250.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,190,600.00	4,340,000.00
Нормативт зардал	-	3,151,000.00

Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	3,151,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	24,301,900.00	16,080,050.00
Багаж, техник, хэрэгсэл	1,586,000.00	1,180,100.00
Урсгал засвар	22,715,900.00	14,899,950.00
Томилолт, зочны зардал	22,356,791.50	32,891,700.00
Гадаад албан томилолт	11,468,791.50	28,588,500.00
Дотоод албан томилолт	10,888,000.00	4,303,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,703,476.00	22,126,065.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,898,271.00	20,703,135.00
Даатгалын үйлчилгээ	407,100.00	562,930.00
Тээврийн хэрэгслийн татвар	288,105.00	300,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	450,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	135,117,156.00	90,532,350.05
Бараа үйлчилгээний бусад зардал	93,810,656.00	89,784,350.05
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	41,306,500.00	748,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,053,185.00	60,301,103.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	38,828,603.00
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	38,828,603.00
Бусад урсгал шилжүүлэг	39,053,185.00	2,000,000.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,457,185.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,596,000.00	2,000,000.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	19,472,500.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,472,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	38,154,990.00	39,155,900.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	38,154,990.00	39,155,900.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,154,990.00	39,155,900.00
Дотоод эх үүсвэрээр	38,154,990.00	39,155,900.00
Тоног төхөөрөмж	25,936,000.00	14,074,900.00
Бусад хөрөнгө	12,218,990.00	25,081,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(38,154,990.00)	(39,155,900.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	-

1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/			
	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,829,377.9	27,250,859.4	1,832,341,998.5	2,105,422,235.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,829,377.9	27,250,859.4	1,832,341,998.5	2,105,422,235.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	541,677,672.9	541,677,672.9
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,829,377.9	27,250,859.4	2,374,019,671.4	2,647,099,908.7
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	245,829,377.9	27,250,859.4	2,374,019,671.4	2,647,099,908.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,829,377.9	27,250,859.4	2,374,019,671.4	2,647,099,908.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	547,718,204.2	547,718,204.2
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,829,377.9	27,250,859.4	2,921,737,875.5	3,194,818,112.8

1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,401,802,800.00	1,253,953,182.61
УРСГАЛ ЗАРДАЛ	1,382,802,800.00	1,234,953,182.61
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,326,440,700.00	1,194,124,579.61
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	746,561,600.00	724,649,574.81
Үндсэн цалин	357,576,800.00	353,106,619.59
Нэмэгдэл	310,183,800.00	300,728,576.32
Унаа хоолны хөнгөлөлт	29,388,000.00	27,098,446.04
Урамшуулал	49,413,000.00	43,715,932.86
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,320,200.00	92,252,400.49
Тэтгэврийн даатгал	63,457,700.00	63,103,214.73
Тэтгэмжийн даатгал	7,465,600.00	7,423,866.47
ҮОМШӨ-ний даатгал	3,732,800.00	3,620,903.21
Ажилгүйдлийн даатгал	3,732,800.00	3,620,903.21
Эрүүл мэндийн даатгал	14,931,300.00	14,483,512.87
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,873,600.00	158,353,489.26
Гэрэл, цахилгаан	37,000,000.00	20,479,953.90
Түлш, халаалт	137,873,600.00	137,873,535.36
Хангамж, бараа материалын зардал	30,811,400.00	34,459,550.00
Бичиг хэрэг	3,850,000.00	3,568,100.00
Тээвэр, шатахуун	14,400,000.00	13,400,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,631,100.00	2,871,200.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,280,300.00	10,280,250.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,650,000.00	4,340,000.00
Нормативт зардал	9,200,000.00	3,151,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,200,000.00	3,151,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	45,624,900.00	36,235,950.00
Багаж, техник, хэрэгсэл	20,124,900.00	15,255,000.00
Тавилга	9,000,000.00	6,081,000.00
Урсгал засвар	16,500,000.00	14,899,950.00
Томилолт, зочны зардал	39,400,000.00	32,891,700.00
Гадаад албан томилолт	32,000,000.00	28,588,500.00
Дотоод албан томилолт	7,400,000.00	4,303,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,395,400.00	22,126,065.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,972,400.00	20,703,135.00
Даатгалын үйлчилгээ	563,000.00	562,930.00
Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	112,253,600.00	90,004,850.05
Бараа үйлчилгээний бусад зардал	110,553,600.00	89,256,850.05

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,700,000.00	748,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,362,100.00	40,828,603.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг	54,362,100.00	38,828,603.00
Засгийн газрын дотоод шилжүүлэг	54,362,100.00	38,828,603.00
Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,000,000.00	19,000,000.00
Дотоод эх үүсвэрээр	19,000,000.00	19,000,000.00
Бусад хөрөнгө	19,000,000.00	19,000,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,401,802,800.00	1,253,953,182.61
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,366,802,800.00	1,218,159,682.61
Орон нутгийн төсвөөс	1,366,802,800.00	1,218,159,682.61
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,000,000.00	35,793,500.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	793,500.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	35,000,000.00	35,000,000.00

1.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	3,468,418.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	3,468,418.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	3,468,418.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	514,500.00
Нэмэгдэл	-	514,500.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	59,168.00
Тэтгэврийн даатгал	-	59,168.00
Хангамж, бараа материалын зардал	-	2,367,250.00
Бичиг хэрэг	-	1,190,000.00
Тээвэр, шатахуун	-	1,087,250.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	90,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	527,500.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	527,500.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	19,472,500.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,472,500.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	22,940,918.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	22,940,918.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	21,750,918.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,190,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2460.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд урсгал засварын зардлын 19,185.0 мянган төгрөгийг багаж техник хэрэгслийн зардалд тусгасан,
- Үндсэн хөрөнгийн тайланд 6 дансны элэгдлийг 80,854.8 мянган төгрөгөөр дутуу бодсон, санхүүгийн тайланд тусгаагүй,

Аудитаар нийт 205,101.4 мянган төгрөгийн зөрчил илэрсний 157,556.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 33,176.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 17,048.5 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоосон..

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 50,224.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс Их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

- ЗДТГ-ын даргын 2025 оны Б/29 дүгээр тушаалаар Гамшгаас хамгаалах хуулийн 52.1 дэх заалтыг үндэслэн 7 албан хаагчид тус бүр 10 хувийн урамшуулалд 895,700.00 (найман зуун ерэн таван мянга долоон зуун) төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"* 16 дугаар зүйлийн "16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;"* ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно." гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч байгаль орчны улсын байцаагч Ж.Батдоржид хавсран гүйцэтгэх цалингийн зөрүүг олгохдоо бүх нэмэгдлийг тооцон бодож гарт олгох цалингийн зөрүүг 5,594,982.00 (таван сая таван зуун ерэн дөрвөн мянга есөн зуун наян хоёр) төгрөгөөр илүү олгосон байна. Энэ нь ЗГ-ын 2019 оны 09 дүгээр тогтоол баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.1-д "Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно." гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ЗДТГ-ын ажилтан албан хаагчдад нийт 20 ажлын хувцсыг авахдаа нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 1,920,000.00 (нэг сая есөн зуун хорин мянга), бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1,440,000.00 (нэг сая дөрвөн зуун дөчин мянга) нийт 2,680,000.00 (хоёр сая зургаан зуун наян мянган) төгрөгийг зарцуулан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д *"Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно."* гэсэн заалттай нийцэхгүй байна.

- ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг нийгмийн бодлогын мэргэжилтэн 2 сар гүйцэтгэж 824,000.00 (найман зуун хорин дөрвөн мянга), хууль эрх зүйн мэргэжилтний ажлыг төсөв төрийн сангийн мэргэжилтэн 2 сар гүйцэтгэж 1,026,400.00 (нэг сая хорин зургаан мянга дөрвөн зуун) нийт 1,850,400 (дөрвөн сая таван зуун гучин мянга дөрвөн зуун) төгрөгийг цалин олгосон байна.
- 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж төрийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан үндэслэлээр санхүүгийн албаны дарга Б.Алтанзаяад 1,539,000.00 (нэг сая таван зуун гучин есөн мянга), нягтлан бодогч Ц.Ганбатад 1,559,000.00 (нэг сая таван зуун тавин есөн мянга) төгрөгийг цалингийн сангаас урамшуулалд олгосон байна.
- Нягтлан бодогч Б.Хүрэлсүвд нь 2025 оны 2 дугаар сараас ажилд орсон байхад улирлын урамшуулал өгөхдөө 45 хувиар тооцон 249,440.00 (хоёр зуун дөчин есөн мянга дөрвөн зуун дөчин) төгрөг илүү олгосон байна. Энэ нь ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-д *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна."* гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага

- Санхүүгийн албаны дарга Б.Алтанзаяа нь татварын мэргэшсэн зөвлөхөөр мэргэшсэн эрхийн нэмэгдэл 25 хувиар тооцон 4,617,000.00 (дөрвөн сая зургаан зуун арван долоон мянга) төгрөгийг авсан байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2-д *"захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс;"*, НББ-ийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно."* гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.
- ЗДТГ-ын данснаас шатахуун, бичиг хэрэг, хог хаягдлын зэрэг зардлаас 6 удаагийн 6,559,000.00 (зургаан сая таван зуун тавин есөн мянган) төгрөгийг бэлэн мөнгөөр нярвын дансанд шилжүүлэн үүнээс 3,880,000.00 (гурван сая найман зуун наян мянган) төгрөгийг зарцуулаагүй үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 444 тогтоолоор баталсан *"Төрийн сангийн үйл ажиллагааны журам"*-ын 3.6.6-д *"Төсвийн байгууллага нь төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвхөн бэлэн мөнгөний үйлчилгээ авах зорилгоор ЖМС-г картын дансандаа шилжүүлэн авна;"* гэсэн заалттай нийцэхгүй байна.
- Гадаад албан томилолтын зардлаас хөх хотод туршлага судлах ажлаар 2025 оны 08 дугаар сарын 11-15-нд 11 албан хаагчид тус бүр 2200.0 мянган төгрөгийг олгосон, албан томилолтоор ажиллах удирдамж төлөвлөөгөө, ажиллах газрын урилга, албан бичиггүй байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан *"Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"*-ын 2.1-д *"Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно"* гэсэн заалттай

нийцэхгүй байна.

3.3 ЗӨВЛӨМЖ:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт 1: Үндсэн хөрөнгийн дансанд анхны үнэ элэгдлээрээ нөхсөн 68 нэр төрлийн 341 ширхэг 109596.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.3 дахь " засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах;" , Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ"

Зөвлөмж: Хөрөнгийг данснаас хасах, үнэ шинэчлэн тогтоох саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, гарсан шийдвэрийн дагуу хөдөлгөөн өөрчлөлтийг хийх.

Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт 2: Засаг даргын нөөц хөрөнгөөс сургалтын төлбөрт 8,160.7, ерөнхий боловсролын сургуулийн автобусны оролцоо 39,800.0 мянган төгрөг зэрэг төлөвлөж болох зардлуудыг зарцуулсан байна.

Энэ нь Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам-ын 3.1.2-д "урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх;

Зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгөд төлөвлөх боломжтой зардлыг тусган зарцуулахгүй байх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

бодогч Ц.Ганбатад 1559.0 мянган төгрөгийн урамшуулал цалин олгосон байна.													
Нягтлан бодогч Б.Хүрэлсүвд нь 2025 оны 2 дугаар сараас ажилд орсон байхад улирлын урамшуулал өгөхдөө 45 хувиар тооцон олгосон,	1	249.4	1	249.4									
Санхүүгийн албаны дарга Алтанзаяа нь татварын мэргэшсэн зөвлөхөөр мэргэшсэн эрхийн нэмэгдэл 25 хувиар тооцон 4617.0 мянган төгрөг нэмэгдэл авсан,	1	4617.0			1	4,617.0							
Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 1920.0, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1440.0 мянган төгрөгийг зарцуулан ЗДТГ-ын ажилтан албан хаагчдад нийт 20 ажлын хувцас авсан,	1	2680.0	1	2680.0									
ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн ажлыг нийгмийн бодлогын мэргэжилтэн 2 сар 824.0, хууль эрх зүйн мэргэжилтний ажлыг төсөв төрийн сангийн мэргэжилтэн 2 сар 1026.4 мянган төгрөгийн цалинг авсан,	1	1850.0	1	1850.0									
ЗДТГ-ын данснаас шатахуун, бичиг хэрэг, хог хаягдлын зэрэг зардлаас 6 удаагийн 6559.0 мянган төгрөгийг бэлэн мөнгөөр няравын дансанд шилжүүлэн зарцуулсан, үүнээс 3880.0 мянган төгрөгийг зарцуулаагүй,					1	6,559.0							
Гадаад албан томилолтын зардлаас хөх хот туршлага судлах ажлаар 2025 оны 08 дугаар сарын 11-15-нд 11 албан хаагчид тус бүр 2200.0 мянган төгрөгийг олгосон, албан томилолтоор ажиллах удирдамж төлөвлөөгөө, ажиллах газрын урилга, албан бичиг байхгүй,					1	22,000.0							
Үндсэн хөрөнгийн дансанд анхны үнэ элэгдлээрээ нөхсөн 68 нэр төрлийн 341 ширхэг 109596.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй,							1	109,596.2					

Засаг даргын нөөц хөрөнгөөс сургалтын төлбөрт 8160.7, ерөнхий боловсролын сургуулийн автобусны оролцоо 39800.0 мянган төгрөг зэрэг төлөвлөж болох зардлуудыг зарцуулсан,							1	47,960.7				
Дүн			6	14,368.5	3	33,176.0	2	157556.9				

-oOo-